| Нэмэлт санхүүжилтийн орлого                                                                                 | -          | 64,842,596,756.64        |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж                                         | -          | 3,471,865,957.52         |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | -          | 18,215,693,916.40        |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | -          | 26,159,461,251.19        |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | -          | 16,995,575,631.53        |
| Төсвийн урамшуулал                                                                                          | -          | -                        |
| <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>                                                             | -          | <b>(15,332,390.75)</b>   |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                                                            | -          | 20,238,205.81            |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                                                           | -          | 4,905,815.06             |



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний үйл ажиллагаа

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь зорилгоо “төрт ёс, түүх соёл, өв уламжлал, ёс заншлаа эрхэмлэн дээдэлсэн, ёс суртахуунтай, соёл, бие бялдрын боловсрол эзэмшсэн, эх оронч, өв тэгш монгол хүнийг төлөвшүүлж, залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлэн, соёл, спорт, аялал жуулчлалын салбарын олон улсад өрсөлдөх чадварыг тогтвортой өсгөж, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар үндэсний бахархал, нэгдмэл байдлыг бататган бэхжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд дараах тэргүүлэх чиглэлтэй ажиллаж байна. Үүнд:

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжил, оролцоог дэмжих нэгдсэн бодлого тодорхойлох;
- Эрхлэх асуудлын хүрээний салбарын цахим бодлого, төлөвлөлтийг тодорхойлж, мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дижитал шилжилтийг эрчимжүүлэх;
- Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, олон нийт, нийгмийг соён гэгээрүүлэх;
- Соёл, урлагийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгох;
- Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх, үнэ цэнэ байдлыг нэмэгдүүлэх;
- Иргэдийн бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;
- Тогтвортой хөгжлийг дэмжсэн дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;
- Залуучуудын хөгжил оролцоог дэмжиж, үнэлэмжийг нэмэгдүүлэх;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн чиглэлээр оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгож, салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, олон талт, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;
- Эрхлэх асуудлын хүрээний статистикийн мэдээллийг боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх, салбарын нэгдсэн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх, сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаад хамтын ажиллагаа, олон улсын сурталчилгааг хөгжүүлэх.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь үйл ажиллагааны тэргүүлэх 2 чиглэл, эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх стратегийн 4 зорилт тавьж 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлаар тусгасан 4 зорилгын хүрээнд 13 арга хэмжээний хэрэгжилтийг 75 хувиар тайлагнасан байна.

#### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Монгол Улсын Засаг

захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,
- Засгийн газрын бүтцийн тухай хууль,
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Төсвийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Соёлын тухай хууль /өөрчлөн найруулсан/
- Биеийн тамир, спортын тухай хууль /шинэчилсэн найруулга/,
- Хөдөлмөрийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль /нэмэлт оруулах тухай/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /нэмэлт өөрчлөлт оруулах тухай/,

Засгийн газрын 2024 оны 18 дугаар “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” тогтоолоор яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт бүтцийг шинэчлэн баталсан байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас харьяа 496 байгууллагаас 430 байгууллагын 2023 оны үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудитыг гүйцэтгэж, 49 байгууллага, 2 тусгай сан, 1 төрийн өмчит үйлдвэрийн газарт эрсдэлийн үнэлгээ, 8 дотоод аудит, 2 дотоод хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Соёлын сайдын 2022 оны тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг одоо мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хийгдсэн ч шинэ бүтэц зохион байгуулалт, онцлогт тохируулан шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341

дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 585,361.4 сая төгрөгөөр буюу 59.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт                                           | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл    | Зөрүү            |
|----------------------------------------------------|------------------|--------------------|------------------|
| Мөнгөн хөрөнгө                                     | 46,755.2         | 27,002.9           | (19,752.3)       |
| Авлага                                             | 3,342.5          | 8,771.6            | 5,429.1          |
| Урьдчилгаа                                         | 5,906.4          | 8,541.6            | 2,635.1          |
| Бараа материал                                     | 30,502.1         | 42,557.9           | 12,055.8         |
| Нөөцийн бараа                                      | 520.1            | 369.5              | (150.6)          |
| Бусад эргэлтийн хөрөнгө                            | 251,167.1        | 551,984.9          | 300,817.8        |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                      | -                | 1,000.0            | 1,000.0          |
| Үндсэн хөрөнгө                                     | 637,781.3        | 921,107.8          | 283,326.5        |
| <b>Нийт хөрөнгийн дүн iii=i+ii</b>                 | <b>975,974.8</b> | <b>1,561,336.1</b> | <b>585,361.4</b> |
| Нийт өр төлбөр                                     | 2,197.3          | 4,498.3            | 2,301.1          |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн                           | 973,777.5        | 1,556,837.8        | 583,060.3        |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн vi=iv+v</b> | <b>975,974.8</b> | <b>1,561,336.1</b> | <b>585,361.4</b> |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 27,002.9 сая төгрөг болж өмнөх оноос 19,752.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| Үзүүлэлт                      | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+) Бууралт (-) |
|-------------------------------|-----------------|-----------------|-----------------------|
| Кассын бэлэн мөнгө            | 1.3             | 4.9             | 3.6                   |
| Төрийн сангийн харилцах       | 46,456.1        | 26,646.5        | (19,809.6)            |
| Арилжааны банк дахь харилцах  | 277.3           | 339.9           | 62.6                  |
| Бусад төсөл, нөөцийн харилцах | -               | 11.6            | 11.6                  |
| Нэмэлт санхүүжилтийн харилцах | 20.2            | 46.2            | 26.0                  |
| <b>Дүн</b>                    | <b>46,755.2</b> | <b>27,002.9</b> | <b>(19,752.3)</b>     |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд Барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоол, 2022 оны 495 дугаар тогтоол, 2023 оны 497 дугаар тогтоол, 2024 оны 249 дүгээр тогтоолоор байршуулсан 37 төсөл арга хэмжээний санхүүжилт болон барилгын чанарын баталгааны барьцааны 25,853.7 сая төгрөг, Захиалагчийн техник хяналтын 301.2 сая төгрөг, Арилжааны банкны үлдэгдэлд Монгол кино нэгтгэл ТӨҮГ болон Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төвийн харилцахын үлдэгдэл болох 339.8 сая төгрөг, Улсын дуурь бүжгийн эрдмийн театрийн 4.6 сая төгрөг, Соёл, урлагийн газар 480.1 сая төгрөг, Биеийн тамир, спортын улсын хорооны 23.1 сая төгрөг байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурахад бүтэц зохион байгуулалтаар шилжиж ирсэн байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 5,182.0 сая төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн

403 байгууллага болон Кино урлагийг дэмжих сангийн өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 11,544.7 сая төгрөгийг тайлант онд төвлөрүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

**Аудитын илрүүлэлт:**

-Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативаас томилолтын болон шатахууны зардлыг 8.9 сая төгрөгөөр илүү тооцож олгосон /Дуурь бүжгийн эрдмийн театр 7.0 сая төгрөг, Соёлын өвийн үндэсний төв 1.4 сая төгрөг, Булган аймгийн төв номын сан 0.5 сая төгрөг/

-Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 67.8 сая төгрөгийг зарцуулсан. /Баянхонгор аймгийн Галуут сумын соёлын төв 2.5 сая төгрөг, Баянхонгор аймгийн түүх угсаатны зүйн музей 5.0 сая төгрөг, Булган аймгийн төв номын сан 1.8 сая төгрөг, Боржигин өв музей 0.7 сая төгрөг, Дуурь бүжгийн эрдмийн театр 14.1 сая төгрөг, Соёлын өвийн үндэсний төв 30.5 сая төгрөг, Уран зургийн галерей 1.6 сая төгрөг, Хүүхдийн төв номын сан 11.5 сая төгрөг/

-Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж цахим дэлгүүрээс бараа, ажил үйлчилгээг худалдан аваагүй, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, бичиг хэргийн зардлыг хэт өндөр төлөвлөж зарцуулсан, хууль тогтоомжид заасан хэлбэрээс өөр тэтгэмж, урамшуулал олгосон. /Нийслэлийн Соёл урлагийн газар 10.9 сая төгрөг, Уран зургийн галерей, Жаахан шарга театр 4.3 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар 2.5 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Соёлын төв 3.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн нийтийн номын сан 0.4 сая төгрөг/

-Соёлын төвийн дарга нар өөртөө тушаал гаргаж 2.6 сая төгрөгийн урамшуулал авсан./ Баянхонгор аймгийн Галуут сумын Соёлын төв 1.4 сая төгрөг, Ховд аймгийн Чандмань сумын соёлын төв 0.6 сая төгрөг, Сүхбаатар аймгийн нийтийн номын сан 0.6 сая төгрөг/

-Цалин, хөлс, шагнал, урамшуулалд нийт 9.3 сая төгрөгийг үндэслэлгүй холбогдох хууль, журмыг зөрчиж олгосон/ Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Соёлын төв 1.8 сая төгрөг, Дорнод аймгийн Чойбалсан сумын Соёлын төв 0.7 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум сумын Соёлын төв 6.4 сая төгрөг, Хэнтий аймгийн нийтийн номын сан 0.4 сая төгрөг/

-Засгийн газрын 2022 оны 495 дугаар тогтоолын Соёлын төвийн барилга, 240 суудал /Хэнтий, Мөрөн сум/, Соёлын төвийн барилга, 240 суудал /Булган, Бугат сум/, "Монголын нууц товчоо"цогцолборын барилгын барьцаа /Хэнтий Дэлгэрхаан/, "Шихихутаг нууц товчоо" түүхэн АЖЦ Барилгын барьцаа /Хэнтий Норовлин/ ЗГ-ын 456-р тогтоолоор нийт 5,960.2 сая төгрөгийг төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажил бүрэн хийгдэж хүлээж аваагүй, хийгдэж байгаа зэрэг маргаантай байдлаас шалтгаалан төсөл арга хэмжээний үйл ажиллагаа удаашралтай байна. /Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны барьцаа хөрөнгө 5,960.2 сая төгрөг/

-Төрийн сан дахь Барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэл 1,081.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. /Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны барьцаа хөрөнгө 1,081.9 сая төгрөг/

-Биеийн тамир спортын улсын хороо 7,211.2 сая төгрөгийг зарлагын гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй орхигдуулсан байна.

-Төсвийг 15.0 сая төгрөгөөр зориулалт бусаар зарцуулсан. /Говийн байгаль, түүхийн музей 0.1 сая төгрөг, Театрын музей 0.5 сая төгрөг, Улсын хүүхэлдэйн театр 9.4 сая төгрөг, Уран зургийн галерей, Хүүхдийн төв номын сан 2.0 сая төгрөг, Чингис хааны музей, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын соёл, спортын төв 1.6 сая төгрөг, Дорноговь аймгийн Хөвсгөл сумын соёл, спортын төв 1.0 сая төгрөг, Дорноговь аймгийн соёл, урлагийн газар 0.2 сая төгрөг, Дорноговь аймгийн Өргөн сумын Соёлын төв 0.2 сая төгрөг /

-Төсөвт төвлөрүүлэх ёстой 47.6 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. /Дуурь бүжгийн эрдмийн театр 4.7 сая төгрөг, Чойжин ламын сүм музей 19.8 сая төгрөг, Дорнод аймгийн номын сан 22.3 сая төгрөг, Завхан аймгийн Яруу сумын Соёлын төв 0.9 сая төгрөг/

-Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой нийт 162.0 сая төгрөгийн бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолж, тайлагнасан. /Баян-Өлгий аймгийн хөгжимт драмын театр 44.2 сая төгрөг, Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газар 0.2 сая төгрөг, Баянхонгор аймгийн нийтийн номын сан 0.1 сая төгрөг, Баянхонгор аймгийн түүх угсаатны зүйн музей 9.5 сая төгрөг, Биеийн тамир спортын улсын хороо 46.8 сая төгрөг, Булган аймгийн төв номын сан 0.2 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Соёлын төв 2.0 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Соёлын төв 0.7 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Соёлын төв 4.0 сая төгрөг, Говь-

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

сүмбэр аймгийн боржигин чуулга 1.0 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн нийтийн номын сан 1.4 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Хонгор сумын Соёлын төв 0.7 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Соёлын төв 0.6 сая төгрөг, Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Соёлын төв, Соёл урлагийн газар 48.2 сая төгрөг, Сүхбаатар аймгийн нийтийн номын сан 1.0 сая төгрөг, Хэнтий аймгийн Дархан сумын Соёлын төв 1.3 сая төгрөг/

### 3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 8,771.6 сая төгрөг болж өмнөх оноос 5,429.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт                        | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/<br>Өсөлт (+)<br>Бууралт (-) |
|---------------------------------|----------------|-----------------|---------------------------------------------|
|                                 |                |                 | Бууралт (-)                                 |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 69.4           | 163.3           | 93.9                                        |
| Төлбөртэй үйлчилгээний авлага   | 82.4           | 284.1           | 201.7                                       |
| Татаас, санхүүжилтийн авлага    | 2,664.2        | 5,688.6         | 3,024.4                                     |
| Дансны авлага /ТӨҮГ/            | 6.9            | 147.7           | 140.8                                       |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/    | 0.0            | 2.9             | 2.9                                         |
| Байгууллагаас авах авлага       | 332.8          | 2,294.8         | 1,962.0                                     |
| Хувь хүмүүсээс авах авлага      | 186.8          | 190.1           | 3.3                                         |
| <b>Дүн</b>                      | <b>3,342.5</b> | <b>8,771.6</b>  | <b>5,429.1</b>                              |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Авлага дансны үлдэгдэл өсөхөд татаас, санхүүжилтийн авлага 3,024.4 сая төгрөгөөр, байгууллагаас авах авлага 1,962.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Татаас, санхүүжилтийн авлагын үлдэгдэлд Чингис хааны музей 4,435.4 сая төгрөг, Улсын драмын эрдмийн театр 400.0 сая төгрөг, Соёл, урлагийн газар 264.7 сая төгрөг, Кино урлагийг дэмжих сан 202.5 сая төгрөг, Богд хааны ордон музей 114.4 сая төгрөг, Соёлын өвийн төв 101.2 сая төгрөг, Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга 70.0 сая төгрөг, Хүүхэд залуучуудын театр 50.4 сая төгрөг, Үндэсний номын сан 33.0 сая төгрөг, Кино урлагийн зөвлөлийн ажлын алба 13.9 сая төгрөг, гүйцэтгэл үр дүнгээр олгох санхүүжилттэй байгууллагын 2.6 сая төгрөг, БТСУХ 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна;
- Авлагын өсөлтөд Чингис хаан музейн авлага өмнөх оноос 2,208.7 сая төгрөгөөр, Улсын драмын эрдмийн театр 398.6 сая төгрөгөөр, Кино урлагийг дэмжих сан 202.5 сая төгрөгөөр, Соёл урлагийн газар 295.4 сая төгрөгөөр, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв 149.4 сая төгрөгөөр, Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга 156.7 сая төгрөгөөр, Богд хаан музей 114.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

-Авлагын 130.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /Дархан-Уул аймгийн залуучууд театр 7.5 сая төгрөг, Ховд аймгийн Алтай сумын соёлын төв, Ховд аймгийн Мөст сумын соёлын төв 3.1 сая төгрөг, Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв 119.7 сая төгрөг/

-Хугацаа хэтэрсэн олон жилийн насжилттай 41.6 сая төгрөгийн авлага байна. /Богд хааны ордон музей 27.8 сая төгрөг, Дуурь бүжгийн эрдмийн театр 8.0 сая төгрөг, Дундговь аймгийн Төв номын сан 5.8 сая төгрөг/

-Тайлант онд төсвийг зохистой удирдаагүйгээс 579.1 сая төгрөгийн авлага шинээр үүсгэж тайлагнасан /Биеийн тамир спортын улсын хороо 561.7 сая төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 3.0 сая төгрөг, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Соёлын төв 1.7 сая төгрөг, Төв аймгийн Баянчандмань сумын Соёлын төв 0.01 сая төгрөг, Төв аймгийн Өндөрширээт сумын

Соёлын төв 0.01 сая төгрөг, Ховд аймгийн Мянгад сумын соёлын төв 2.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Ханх сумын Соёлын төв 10.4 сая төгрөг/

-Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой нийт 28.0 сая төгрөгийн бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолж, тайлагнасан./ Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын соёл гэгээрлийн төв 2.3 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга 0.4 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Соёлын төв 0.5 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Соёлын төв 0.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны соёлын төв 0.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Соёлын төв 1.1 сая төгрөг, Төв аймгийн номын сан 0.7 сая төгрөг, Улсын хүүхэлдэйн театр 4.1 сая төгрөг, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын соёлын төв 0.7 сая төгрөг, Хүүхдийн төв номын сан 17.0 сая төгрөг/

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 8,541.6 сая төгрөг болж өмнөх оноос 2,635.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

| Үзүүлэлт                          | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөг/<br>Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|-----------------------------------|----------------|-----------------|-------------------------------------------|
| Урьдчилж гарсан зардал            | 5,868.1        | 8,375.0         | 2,506.9                                   |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 15.0           | 12.3            | (2.7)                                     |
| Цалингийн урьдчилгаа              | 0.2            | 0.2             | 0.0                                       |
| Томилолтын урьдчилгаа             | 23.1           | 154.0           | 130.9                                     |
| <b>Дүн</b>                        | <b>5,906.4</b> | <b>8,541.5</b>  | <b>2,635.1</b>                            |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд БТСУХ 3,776.4 сая төгрөг, хөтөлбөр арга хэмжээний 2,459.0 сая төгрөг, Кино урлагийг дэмжих сан 1,106.1 сая төгрөг, Улсын хүүхэлдэйн театрын 347.9 сая төгрөг, Чингис хааны өв, соёлын хүрээлэнгийн 369.9 сая төгрөг болон бусад 12 байгууллагын 482.3 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Урьдчилж гарсан зардал нь өмнөх оноос 2,635.1 сая төгрөгөөр өссөн нь бүтэц зохион байгуулалтаар Биеийн тамир, спортын улсын хорооны шилжиж ирсэнтэй холбоотой 3,776.3 сая төгрөгийн урьдчилгаа нэмэгдэж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөтөлбөр арга хэмжээний урьдчилж гарсан зардал 1,160.2 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

### Аудитын илрүүлэлт:

-Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой нийт 29.2 сая төгрөгийн бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолж, тайлагнасан /Нийслэлийн Соёл урлагийн газар 27.0 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Соёлын төв 1.1 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Соёлын төв 1.1 сая төгрөг/

-Дансны ангилал зөрчиж 370.0 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг зардлаар бүртгэсэн /Чингис хааны өв соёлын хүрээлэн 370.0 сая төгрөг/

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 42,557.9 сая төгрөг болж өмнөх оноос 12,055.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт            | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөг/<br>Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|---------------------|-----------------|-----------------|-------------------------------------------|
| Түүхий эд материал  | 6,929.5         | 10,847.0        | 3,917.5                                   |
| Хангамжийн материал | 23,572.7        | 31,710.9        | 8,138.3                                   |
| <b>Дүн</b>          | <b>30,502.2</b> | <b>42,557.9</b> | <b>12,055.8</b>                           |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Бараа материалын дансны өсөлтөд бүтэц зохион байгуулалтаар Биеийн тамир, спортын салбарын 33 байгууллага шилжиж ирснээр 4,491.7 сая төгрөгийн бараа материал, Булган аймгийн номын сан, Хүүхэд залуучуудын театр, Үндэсний номын сан шинээр ашиглалтад орсонтой холбоотой 24,630.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд голлон нөлөөлсөн байна.

#### Аудитын илрүүлэлт:

-Цахим дэлгүүрээс 14.3 сая төгрөгийн бараа материал худалдан аваагүй мөн төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн 374.3 сая төгрөг байна./Дуурь бүжгийн эрдмийн театр 272.7 сая төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам- 9.0 сая төгрөг, Чойжин ламын сүм - 92.6 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Соёлын төв-7.4 сая төгрөг, Төгрөг сумын Соёлын төв- 6.9 сая төгрөг /

-Тайлант оны хагас болон бүтэн жилийн тооллогыг зохион байгуулаагүйгээс 114.2 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй /Төв аймгийн Баяндэлгэр сумын Соёлын төв - 0.4сая төгрөг, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын төв-0, Цогт- Овоо сумын Соёлын төв -107.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Соёлын төв -6.0сая төгрөг, Говь-Алтай аймгийн Цогт сумын Соёлын төв/

-Анхан шатны баримтын бүрдэл дутуу 74.7 сая төгрөгийн ажил гүйлгээ хөтөлсөн. /Байгалийн түүхийн музей -31.5 сая төгрөг, Хүүхдийн төв номын сан -1.6 сая төгрөг, Өмнөговь аймгийн Соёл урлагийн газар -5.1 сая төгрөг, Баян-Овоо сумын Соёлын төв-1.0 сая төгрөг, Цогт-Овоо сумын Соёлын төв-13.8 сая төгрөг, Төв аймгийн Алтанбулаг сумын Соёлын төв-1.7 сая төгрөг, Баян-Өнжүүл сумын Соёлын төв-1.1сая төгрөг, Баянхангай сумын Соёлын төв- 1.0сая төгрөг, Баянчандмань сумын Соёлын төв-1.0 сая төгрөг, Борнуур сумын Соёлын төв- 1.2 сая төгрөг, Зуунмод сумын Соёлын төв-1.0 сая төгрөг, Сүмбэр сумын Соёлын төв-2.0 сая төгрөг, Угтаал сумын Соёлын төв-4.2 сая төгрөг,Цээл сумын Соёлын төв -1.0 сая төгрөг, Дархан-уул аймгийн Залуучуудын театр-7.0 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн Баянтал сумын Соёлын төв-0.5 сая төгрөг,Орхон аймгийн Жаргалант сумын Соёлын төв,Сүхбаатар аймгийн Номын сан/

-Бараа материалын эдийн засгийн ангилал болон материалын тоо ширхэг, нэгжийн үнийг 29.2 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн. /Говь-сүмбэр аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар -6.9 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Соёлын төв-0.9 сая төгрөг, Булган аймгийн Дашинчилэн сумын Соёлын төв-21.4 сая төгрөг,Орхон аймгийн Баян-Өндөр сумын Эгшиглэн соёлын төв/

-Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүй 7.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн, 1.7 сая төгрөгийн бараа материал акталсан байна. /Соёлын өвийн үндэсний төв-6.1 сая төгрөг, Үндэсний урлагийн их театр 0.9 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн Баянтал сумын Соёлын төв-1.7 сая төгрөг/

-Бараа материалын дансанд бүртгэлтэй хөрөнгийг түүвэрлэн тооллого хийхэд 9.8 сая төгрөгийн материал дутагдсан./Монголын Үндэсний музей-2.5 сая төгрөг, Соёл урлагийн газар -7.3 сая төгрөг/

-Бараа материалын тайланд үндсэн хөрөнгийн шинжтэй 21.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, Хөрөнгийг бөөн дүнгээр тайлагнасан /Соёл урлагийн газар -2.9 сая төгрөг, Хүүхдийн төв номын сан -0.8 сая төгрөг, Хүүхдийн төв номын сан-1.2 сая төгрөг, Дундговь аймгийн Музей 9.6 сая төгрөг, Говь-сүмбэр аймгийн Баянтал-6.8 сая төгрөг, Дорноговь аймгийн Номын сан, Орхон аймгийн Жаргалант сумын Соёлын төв/

-Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж 3.0 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн байна. /Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Соёлын төв-3.0 сая төгрөг/

#### 3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 551,984.9 сая төгрөг болж өмнөх оноос 300,817.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт                             | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|--------------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 251,167.1      | 551,984.9       | 300,817.8              |
| Дүн                                  | 251,167.1      | 551,984.9       | 300,817.8              |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бусад эргэлтийн хөрөнгө дансанд Соёлын салбарын байгууллагуудын хөрөнгө оруулалтын 328,808.5 сая төгрөг, Спортын салбарын хөрөнгө оруулалтын 216,829.3 сая төгрөг, Биеийн тамир, спортын улсын хорооны 6,347.1 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 921,107.8 сая төгрөг болж өмнөх оноос 283,326.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт                         | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өсөлт (+), Бууралт (-) |
|----------------------------------|------------------|------------------|------------------------|
| <b>Биет хөрөнгө</b>              | <b>613,000.3</b> | <b>878,535.1</b> | <b>265,534.8</b>       |
| Барилга, байгууламж, орон сууц   | 464,062.0        | 713,512.4        | 249,450.4              |
| Авто-тээврийн хэрэгсэл           | 5,103.4          | 8,409.5          | 3,306.0                |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 64,131.5         | 105,303.3        | 41,171.7               |
| Тавилга, аж ахуйн эд хогшил      | 34,154.4         | 48,802.9         | 14,648.5               |
| Зам, гүүрний байгууламж          | 610.0            | 4,274.9          | 3,664.9                |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 118,951.9        | 125,669.0        | 6,717.1                |
| Бусад үндсэн хөрөнгө             | 10,607.7         | 23,717.6         | 13,109.8               |
| Дуусаагүй барилга, байгууламж    | 3,855.4          | 5,260.3          | 1,404.9                |
| Ном                              | 10,349.8         | 11,138.4         | 788.6                  |
| <b>Биет бус хөрөнгө</b>          | <b>24,781.0</b>  | <b>42,572.7</b>  | <b>17,791.7</b>        |
| Программ хангамж                 | 1,459.5          | 2,122.7          | 663.2                  |
| Бусад биет бус хөрөнгө           | 24,032.0         | 41,594.4         | 17,562.4               |
| <b>Дүн</b>                       | <b>637,781.3</b> | <b>921,107.8</b> | <b>283,326.5</b>       |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь тайлант онд нийт 12,004.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив, дахин үнэлгээний нэмэгдэл, бусад үзүүлэлтээр 97,790.3 сая төгрөг, бүтэц зохион байгуулалтын дагуу биеийн тамир, спортын салбарын 34 байгууллага шилжиж ирсэнтэй холбоотой болон шилжүүлэн авсан 268,605.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, 4,941.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасаж, 16,063.1 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, тайлант хугацаанд 77,497.7 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь холбоотой байна.

#### Аудитын илрүүлэлт:

-Анхан шатны баримтын бүрдэл дутуу 25.1 сая төгрөгийн үндсэн хөрөнөө бүртгэсэн./Кино урлагийн зөвлөлийн ажлын алба, Говь сүмбэр аймгийн Баянтал сумын Соёлын төв-6.6 сая төгрөг, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Соёлын төв-18.5 сая төгрөг/

-Үндсэн хөрөнгийн бүртгэлд 9.3 сая төгрөгийн хөрөнгийг нийт дүнгээр бүртгэж, тайлагнасан /Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Соёлын төв -0.7 сая төгрөг, Угтаал сумын Соёлын төв -0.7 сая төгрөг, Өмнөговь аймгийн Манлай сумын Соёлын төв -7.8 сая төгрөг, Монголын Үндэсний музей/

-Тайлант оны хагас болон бүтэн жилийн тооллогыг чанартай зохион байгуулаагүй, хөрөнгийн дутагдлыг нөхөн төлүүлээгүй, зарим хөрөнгийг орхигдуулсан, хөрөнгийн тооллого хийгээгүй зэрэг нийт 892.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй /Богд хааны ордон музей-14.4 сая төгрөг, Соёл урлагийн газар, Улсын драмын эрдмийн театр-0.8 сая төгрөг, Улсын филармони-0.6 сая төгрөг, Чингис хаан музей, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Соёлын төв -0.3 сая төгрөг, Цагаандэлгэр сумын Соёлын төв, Өлзийт сумын Соёлын төв, Увс аймгийн Өмнөговь сумын Соёлын төв -635.3 сая төгрөг, Өлгий сумын Соёлын төв – 83.9 сая төгрөг,

Зүүнхангай сумын Соёлын төв- 2.6 сая төгрөг, Тэс сумын Соёлын төв -97.0 сая төгрөг, Завхан сумын Соёлын төв -57.2 сая төгрөг, Өндөр хангай, Цагаан хангай, сумдын Соёлын төв төгрөг, Архангай аймгийн Номын сан, Булган аймгийн Номын сан, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Цогтцэций сумдын Соёлын төв, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Номын сан, Ховд аймгийн Чандмань, Дарви сумдын Соёлын төв, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Соёлын төв/

-Цахим дэлгүүрээс 5.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан аваагүй /Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Соёлын төв-5.8 сая төгрөг /

-Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын гэрчилгээг Улсын бүртгэлээс аваагүй, үнэлж бүртгэлд тусгаагүй, нэгж талбайн дүнг зөрүүтэй бүртгэсэн зэрэг 106.2 сая төгрөгийн зөрчил байна./Байгалийн түүхийн музей 15.0 сая төгрөг, Улсын төв номын сан, Чингис хаан музей, Үндэсний урлагийн их театр 8.4 сая төгрөг, Төв аймгийн Аргалант сумын Соёлын төв -8.0 сая төгрөг, Батсүмбэр сумын Соёлын төв -43.0 сая төгрөг, Баянцагаан сумын Соёлын төв -11.3 сая төгрөг, Баянчандмань сумын Соёлын төв -10.0 сая төгрөг, Зуунмод сумын Соёлын төв -2.0 сая төгрөг, Угтаал сумын Соёлын төв -8.5 сая төгрөг, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Соёлын төв/

-Үндсэн хөрөнгийн эдийн засгийн ангилал болон тоо ширхэг, нэгжийн үнийг 84.7 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн /Говь сүмбэр аймгийн Баянтал сумын Соёлын төв-9.5 сая төгрөг, Байгалийн түүхийн музей 15.6 сая төгрөг, Богд хааны ордон музей, Дундговь аймгийн Өлзийт сумын Соёлын төв- 54.4 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Хөгжимт драмын театр-4.0 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Соёлын төв -1.2 сая төгрөг/

-Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн 466.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй. /Монгол кино компани-103.2 сая төгрөг, Богд хааны ордон музей, Бишийн тамир спортын улсын хороо, Хүүхдийн төв номын сан, Чингис хаан музей, Архангай аймгийн Музей – 27.0 сая төгрөг, Цэнхэр сумын Соёлын төв – 26.8 сая төгрөг, аймгийн Номын сан -60.9 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театр- 73.5 сая төгрөг, Дорнод аймгийн Номын сан -26.5 сая төгрөг, Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 52.0 сая төгрөг, Өлзийт сумын Соёлын төв – 64.3 сая төгрөг, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Соёлын төв -1.5 сая төгрөг, Мандал-Овоо сумын Соёлын төв -25.9 сая төгрөг, Гурвантэс, Сэрэй сумдын Соёлын төв, Сүхбаатар аймгийн Халзан сумын Соёлын төв -5.2 сая төгрөг, Түвшинширээ сумын Соёлын төв, Булган аймгийн Могод, Хутаг-Өндөр сумдын Соёлын төв, Ховд аймгийн Мөнххайрхан сумын Соёлын төв, Төв аймгийн Номин сан, Орхон аймгийн Жаргалант сумын Соёлын төв, Хүүхэд залуучуудын театр, Дорноговь аймгийн Алтанширээ сумын Соёлын төв, Говь сүмбэр аймгийн Шивээговь сумын Соёлын төв/

-Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй 15.0 сая төгрөгийн алдааг давтан гаргасан /Завхан аймгийн Шилүүстэй сумын Соёлын төв-15.0 сая төгрөг/

- Ажилтан, албан хаагчдын ашиглаж буй эд хөрөнгийг дахин давтагдашгүй кодоор бүртгэлд, хяналт тавьж ажиллаагүй бөгөөд өмчийн хадгалалт, хамгаалалт, хяналтын зохион байгуулалт хангалтгүй /Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Дундговь-Соёлын төв, Монгол кино компани/

### 3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 4,498.3 сая төгрөг болж өмнөх оноос 2,301.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

| Үзүүлэлт                            | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|-------------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Арилжааны банк                      | -              | 40.4            | 40.4                   |
| Ажилчидтай холбогдсон өглөг         | 59.3           | 309.8           | 250.5                  |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг    | 211.7          | 164.1           | (47.5)                 |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 0.0            | 1.1             | 1.1                    |
| Бусад өглөг                         | 1,919.0        | 3,982.9         | 2,063.9                |
| Урьдчилж орсон орлого               | 7.3            | -               | (7.3)                  |
| <b>Дүн</b>                          | <b>2,197.3</b> | <b>4,498.3</b>  | <b>2,301.1</b>         |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөр данс өмнөх оноос 2,301.1 сая төгрөгөөр өссөн нь Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төвийн 2,100.1 сая төгрөг, Биеийн тамир, спортын хорооны 270.7 сая төгрөгийн өглөгөөс шалтгаалжээ.

### 3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,556,837.8 сая төгрөг болж өмнөх оноос 583,060.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

| Үзүүлэлт                              | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл    | /сая төгрөг/<br>Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|---------------------------------------|------------------|--------------------|-------------------------------------------|
| Засгийн газрын хувь оролцоо           | 973,777.5        | 1,556,837.8        | 583,060.3                                 |
| Засгийн газрын оруулсан капитал       | 153,819.6        | 205,222.6          | 51,402.9                                  |
| Улсын төсвийн оруулсан хөрөнгө        | 39,732.3         | 102,980.1          | 63,247.7                                  |
| Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 114,087.3        | 102,242.5          | (11,844.8)                                |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/                   | 145.4            | 35,324.3           | 35,178.9                                  |
| Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/      | 0.0              | 1,012.4            | 1,012.4                                   |
| Хуримтлагдсан үр дүн                  | 628,483.3        | 1,077,397.8        | 448,914.5                                 |
| Өмнөх үеийн үр дүн                    | 469,535.0        | 702,273.5          | 232,738.4                                 |
| <b>Цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>       | <b>973,777.5</b> | <b>1,556,837.8</b> | <b>583,060.3</b>                          |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны өсөлтөд биеийн тамир, спортын салбарын байгууллагууд шилжиж ирсэнтэй холбоотой 208,076.8 сая төгрөг, тайлант хугацааны 375,124.3 сая төгрөгийн үр дүн голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцооны нийт дүнд 208,076.8 сая төгрөгийн бодлогын өөрчлөлт орсон байгаагаас бүтэц зохион байгуулалтын дагуу шилжиж ирсэн 34 байгууллагын өмч 206,927.3 сая төгрөг, бол соёлын салбарын байгууллагуудын бодлогын өөрчлөлтөөр 1,149.5 сая төгрөгийн өөрчлөлт орсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны төсвийн төсөлд зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд 359,252.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 282,924.3 сая төгрөг нийт 642,177.1 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд төсвийн төсөлд хүргүүлсэн саналаас 244,426.0 сая төгрөгөөр буурч 397,751.1 сая төгрөгөөр батлагдсан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар төсвийг 177,566.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 575,318.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн яамны зөвшөөрлөөр төсөвт 12 удаагийн 3,529.2 сая төгрөгийн зохицуулалт хийсэн байна. Төсөвт зохицуулалт хийсэн шалтгааныг авч үзвэл Сангийн яамны 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт



зохицуулалт хийх журам"-д заасны дагуу төсвийн захирагч, зардлын эдийн засгийн зүйл, хөтөлбөр, арга хэмжээний ангиллын дагуу хийсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

#### Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбар нь улсын төсвөөс 505,048.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 491,390.1 сая төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй 13,658.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөв захирагчийн нийт зардлын гүйцэтгэл 491,390.1 сая төгрөг буюу 85.4 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал 64,316.1 сая төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 10,883.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,419.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 7,308.9 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

### 3.5.3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

| Д/д                                       | Код   | Хөтөлбөр, арга хэмжээ                                              | Төлөвлөгөө      | Гүйцэтгэл      | Зөрүү          | Хувь        |
|-------------------------------------------|-------|--------------------------------------------------------------------|-----------------|----------------|----------------|-------------|
| <b>71411 - Хүрээлэн буй орчны бодлого</b> |       |                                                                    |                 |                |                |             |
| 1                                         | 80918 | Бусад                                                              | 16,399.6        | 9,537.1        | 6,862.5        | 58.2        |
| <b>Нийт дүн</b>                           |       |                                                                    | <b>16,399.6</b> | <b>9,537.1</b> | <b>6,862.5</b> | <b>58.2</b> |
| <b>71701 - Биеийн тамир спорт</b>         |       |                                                                    |                 |                |                |             |
| 1                                         | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал                                      | 28,109.9        | 26,558.5       | 1,551.3        | 94.5        |
| 2                                         | 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил                                   | 34.3            | 31.2           | 3.1            | 91.0        |
| 3                                         | 80219 | Харуул, хамгаалалтын зардал                                        | 42.8            | 42.8           | -              | 100.0       |
| 4                                         | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ                                          | 368.2           | 368.2          | -              | 100.0       |
| 5                                         | 80305 | Биеийн тамирын уралдаан, тэмцээн                                   | 1,988.0         | 1,982.8        | 5.2            | 99.7        |
| 6                                         | 80509 | ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж                                   | 117.9           | 113.9          | 4.0            | 96.6        |
| 7                                         | 80704 | Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж | 213.6           | 210.6          | 3.0            | 98.6        |
| 8                                         | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж,                                      | 925.3           | 906.2          | 19.1           | 97.9        |
| 10                                        | 80918 | Бусад                                                              | 71,853.4        | 53,980.0       | 15,228.7       | 78.8        |
| 9                                         | 82101 | Улсын шигшээ багийн үйл ажиллагаа                                  | 25,503.4        | 23,848.9       | 1,654.5        | 93.5        |
| 10                                        | 82102 | Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох                              | 1,384.3         | 1,317.2        | 67.0           | 95.2        |
| 11                                        | 82103 | Олон улсын бусад тэмцээн уралдаанд оролцох                         | 1,737.6         | 1,737.6        | -              | 100.0       |
| 12                                        | 82104 | Дотоодод тэмцээн уралдаан зохиох                                   | 3,009.8         | 2,744.8        | 265.1          | 91.2        |
| 13                                        | 82105 | Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдад олгох                          | 1,896.0         | 1,896.0        | 0.0            | 100.0       |
| 14                                        | 82106 | Нийтийн биеийн тамир                                               | 2,638.4         | 2,243.2        | 395.1          | 85.0        |
| 15                                        | 82107 | Өндөр зэр-н там дас дэмжих                                         | 336.6           | -              | 336.6          | -           |
| 16                                        | 82108 | Үндэсний уламжлалт спорт дэмжих                                    | 284.5           | -              | 284.5          | -           |
| 17                                        | 82109 | Допинг эсрэг ү/ажиллагааг дэмж                                     | 1,067.4         | 871.2          | 196.2          | 81.6        |

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                           |       |                                                                      |           |           |          |       |
|---------------------------|-------|----------------------------------------------------------------------|-----------|-----------|----------|-------|
|                           | 82111 | Эрүүл, идэвхтэй амьдрал                                              | 202.0     | -         | 202.0    | -     |
| 18                        | 82112 | Олимп, паралимпыг дэмжих үйл ажиллагаа                               | 2,438.0   | 2,391.8   | 46.2     | 98.1  |
| 19                        | 82114 | Тусгай Олимп                                                         | 98.1      | 98.1      | -        | 100.0 |
| Нийт дүн                  |       |                                                                      | 144,249.2 | 121,343.0 | 20,261.6 | 84.1  |
| <b>71702 - Соёл урлаг</b> |       |                                                                      |           |           |          |       |
| 1                         | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал                                        | 63,563.7  | 61,200.8  | 2,362.9  | 96.3  |
| 2                         | 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ                               | 354.3     | 331.7     | 22.6     | 93.6  |
| 3                         | 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал                                      | 1,700.0   | 1,700.0   | -        | 100.0 |
| 4                         | 80214 | Уран бүтээл хийлгэх                                                  | 262.0     | 261.9     | 0.1      | 100.0 |
| 5                         | 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил                                     | 93.2      | 92.0      | 1.2      | 98.7  |
| 6                         | 80219 | Харуул, хамгаалалтын зардал                                          | 285.6     | 279.1     | 6.5      | 97.7  |
| 7                         | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ                                            | 243.0     | 243.0     | -        | 100.0 |
| 8                         | 80239 | Тээврийн үйлчилгээ                                                   | 185.0     | 184.9     | 0.1      | 99.9  |
| 9                         | 80511 | Татварын буцаан олголт                                               | 2,000.0   | 2,000.0   | -        | 100.0 |
| 10                        | 80704 | Ахмад дайчин, алдар цолтой ахм                                       | 1,039.0   | 1,037.8   | 1.2      | 99.9  |
| 11                        | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж                                         | 5,958.7   | 5,475.6   | 483.1    | 91.9  |
| 12                        | 80918 | Бусад                                                                | 156,438.4 | 116,858.1 | 44,175.3 | 74.7  |
| 13                        | 81855 | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт                                      | 8,000.0   | 7,795.2   | 204.8    | 97.4  |
| 14                        | 81901 | Соёл урлаг хөгжүүлэх                                                 | 10,716.6  | 10,551.8  | 164.8    | 98.5  |
| 15                        | 81905 | Музейн үзмэр худалдан авах                                           | 56.6      | 0.7       | 55.9     | 1.2   |
| 16                        | 81907 | Түүхийн хүрд баримтат кино бүтээл                                    | 62.2      | 62.2      | -        | 100.0 |
| 17                        | 81908 | Түүх, соёлын дурсгалт зүйлсийг                                       | 631.2     | 622.7     | 8.6      | 98.6  |
| 18                        | 81909 | Музей, түүх, соёлын өвийн сэргээх                                    | 0.6       | 0.6       | -        | 100.0 |
| 19                        | 81914 | Хөгжмийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах                   | 28.3      | 28.3      | -        | 100.0 |
| 20                        | 81916 | Дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын санд худалдаж авах           | 28.3      | 28.3      | -        | 100.0 |
| 21                        | 81918 | Соёл урлагийн олон улсын тэмцээн                                     | 186.0     | 186.0     | -        | 100.0 |
| 22                        | 81919 | Оны шилдэг уран бүтээлч найруулагч шалгаруулах                       | 43.3      | 40.3      | 3.0      | 93.1  |
| 23                        | 81922 | Гадаад дотоодод зохиогдох соёл                                       | 2,923.9   | 2,817.4   | 106.6    | 96.4  |
| 24                        | 81934 | Соёлын бүтээлч үйлдвэрлэл                                            | 2,518.4   | 2,354.8   | 163.6    | 93.5  |
| 25                        | 81936 | Цахим соёл хөтөлбөр                                                  | 500.0     | 124.0     | 376.0    | 24.8  |
| 26                        | 81938 | Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг | 186.1     | 163.9     | 22.2     | 88.1  |
| 27                        | 81939 | Бүх нийтийн соёлын боловсрол                                         | 300.0     | 261.6     | 38.5     | 87.2  |



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                         |       |                                                                                                |           |           |          |       |
|-----------------------------------------|-------|------------------------------------------------------------------------------------------------|-----------|-----------|----------|-------|
| 28                                      | 81941 | Соёлын байгууллагад гүйцэтгэлээр олгох санхүүжилт                                              | 134,623.4 | 126,663.2 | 7,960.2  | 94.1  |
| 29                                      | 81947 | Монгол Улсын Олон улс дахь сурталчилгаа, мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагааны хэрэгжилт | 6,366.0   | 6,245.8   | 120.2    | 98.1  |
| 30                                      | 82801 | Улсын их баяр наадам                                                                           | 2,905.0   | 2,905.0   | -        | 100.0 |
| 31                                      | 83115 | Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр                                                              | 2,475.0   | 2,460.8   | 14.2     | 99.4  |
| Нийт дүн                                |       |                                                                                                | 404,673.8 | 352,977.4 | 56,291.4 | 87.2  |
| <b>71703 - Аялал жуулчлал</b>           |       |                                                                                                |           |           |          |       |
| 1                                       | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал                                                                  | 6,082.7   | 4,665.4   | 1,417.3  | 76.7  |
| 2                                       | 80404 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас                                                      | 1,263.3   | 790.9     | 472.5    | 62.6  |
| Нийт дүн                                |       |                                                                                                | 7,346.0   | 5,456.3   | 1,889.8  | 74.3  |
| <b>71805 - Шинжлэх ухаан, технологи</b> |       |                                                                                                |           |           |          |       |
| 1                                       | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал                                                                  | 1,244.7   | 1,218.2   | 26.5     | 97.9  |
| 2                                       | 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны ажил                                                               | 10.0      | 10.0      | -        | 100.0 |
| 3                                       | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж,                                                                  | 42.9      | 40.9      | 2.0      | 95.3  |
| Нийт дүн                                |       |                                                                                                | 1,297.6   | 1,269.1   | 28.5     | 97.8  |
| <b>72209 - Залуучууд болон оюутнууд</b> |       |                                                                                                |           |           |          |       |
| 1                                       | 83115 | Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр                                                              | 1,351.8   | 807.2     | 544.6    | 59.7  |
| Нийт дүн                                |       |                                                                                                | 1,351.8   | 807.2     | 544.6    | 59.7  |
| Бүгд                                    |       |                                                                                                | 575,318.1 | 491,390.1 | 83,928.0 | 85.4  |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.4 Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 5 хөтөлбөр, 19 хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 11. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

| 71702 Соёл урлаг                                                | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|-----------------------------------------------------------------|--------------|---------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нийтийн номын сангийн байнгын уншигчийн нийт хүн амд эзлэх хувь | 15           | 10.2          | Нийслэл болон аймгийн хэмжээний 26, соёлын төв, соёлын ордны 337 нийт 363 номын сангийн байнгын уншигчийн тоо улсын хэмжээнд 347,502 болж 6-аас дээш насны хүн амын 10.2 хувийг эзэлж байна. Энэ нь суурь түшингээс 3.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Монгол улсад оршин суугаа жилийн дундаж хүн амын өсөлттэй холбоотойгоор номын сангийн байнгын уншигчийн тоо хүрэх түвшиндээ хүрээгүй байна. |
| 10,000 хүнд ногдох номын тоо                                    | 28           | 18.6          | Улсын хэмжээний номын сангийн сан хөмрөгт нийт 6,355,281 ном байна. Энэ нь өмнөх оноос 1.3 хувиар                                                                                                                                                                                                                                                                                                   |

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                                                                                                  |     |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                  |     |       | өссөн бөгөөд 82,686 номоор баяжилт хийгдсэн байна. 10 мянган хүнд ногдох ном 18,587 болж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| Музейн үзэгчийн нийт хүн амд эзлэх хувь                                                                          | 21  | 48.2  | Музейн үзэгчийн тоо 1,646,963 байгаа нь 6-аас дээш насны хүн амын 48.2 хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд музейн нийт үйлчлүүлэгчдийн тоо 2024 онд 1,646,963 болж өмнөх оноос 488,787-аар өссөн. "Музейн нээлттэй өдрүүд" арга хэмжээг 2022 оноос эхлэн улсын хэмжээнд зохион байгуулж тогтмолжсон, тус арга хэмжээг жил бүрийн 3 дугаар сарын эхний 7 хоногт зохион байгуулах Монгол Улсын Засгийн газрын 96 дугаар тогтоол гарсан. Мөн Ковид цар тахлаас хойш жуулчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой музей үзэгчдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.                                            |
| Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо                                                                     | 245 | 262.8 | 2023 онд-Музейн үзмэрийн тоо-250,980 байсан 2024 онд 262,824 болж өсөж 11,844 үзмэр нэмэгдсэн байна. Нэмэгдсэн үзмэрийн мэдээллийг нарийвчлан гаргавал, 142 үзмэр худалдан авсан (138 үзмэр орон нутгийн хөрөнгөөр, 4 төрийн өмчийн хөрөнгөөр), 594 үзмэр бэлэг хандиваар, 9651 үзмэр, эд өлгийн зүйлсийг шилжүүлгээр (ЧХҮМ сан хөмрөгийг баяжуулсан), 889 малтлага судалгаагаа үзмэр эд өлгийн зүйл тус тус нэмэгдэж музейн сан хөмрөг баяжсан байна. 2024 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Соёл, урлагийн цогцолборын дэргэдэх музей шинээр улсын бүртгэлд бүртгэгдсэнээр 569 үзмэр нэмэгдсэн. |
| 10,000 хүнд ногдох соёлын төвийн суудал                                                                          | 300 | 268.1 | Соёлын төв/ордон/-ийн суудлын тоо 91,668 бөгөөд өмнөх оныхоос 2,318 суудлаар өссөн үзүүлэлттэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
| Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо                                                                   | 3.6 | 2.4   | Урлагийн байгууллагын тоглолт үзсэн үзэгчдийн тоо 2023 онд 1,502,315 байсан бол 2024 онд 2,355,296 болж 63.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус онд шинээр Хүүхэд залуучуудын театр ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Мөн жуулчдын тоо өссөнтэй холбоотой.                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>71701 Биеийн тамир, спорт</b>                                                                                 |     |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 6-64 насны бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан хүмүүст А, В, С үнэлгээ авсан хүний эзлэх хувь /хүйсээр/ | 59  | 67.7  | 2024 оны бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан 345,163.0 хүнээс 233,443.0 хүн нь А, В, С үнэлгээ авсан байна. Энэ нь зорилтод түшингээс 8.7 хувиар илүү байна. Сорилыг жилд хавар, намар 2 удаа зохион байгуулдаг бөгөөд мэргэжлийн зөвлөгөө өгч ажилладаг тул давтан өгч буй хүмүүсийн үнэлгээ сайжирдаг.                                                                                                                                                                                                                                                                           |
| Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /олимпын наадам/-ээс авах медаль                                              | 16  | 16    | 2024 онд насанд хүрэгчдийн шигшээ баг, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 3 Алт, 3 Мөнгө, 2 Хүрэл медаль, "Парис-2024" олимпын наадмаас 1 мөнгө, пара-олимпын наадмаас 1 алт, 3 мөнгөн медаль тус тус хүртсэн. Олимп, пара-олимпын жил учраас зарим спортын төрөлд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаагүй болно.                                                                                                                                                                                                                                                      |
| Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /олимпын наадам/-д оролцох эрх авах тамирчид                                  | 58  | 44    | "Парис 2024" зуны олимпын XXXIII наадамд Монгол Улсын баг тамирчид Буудлага, Чөлөөт бөх, Жүдо, Хөнгөн атлетик, Байт харваа, Усанд сэлэлт, Хүндийн өргөлт, Бокс, Дугуй гэсэн нийт 9 спортын төрлөөр 33 (32 тамирчин+1 багийн төрлөөр) тамирчин эрхээ авч оролцлоо. "Парис 2024" зуны пара-олимпын XXXIII наадамд Монгол Улсын баг тамирчид Жүдо, Хөнгөн                                                                                                                                                                                                                                      |

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|                                                                                                                      |     |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                      |     |     | атлетик, Байт харваа, Усанд сэлэлт, Пауэрлифтинг, Таеквондо гэсэн нийт 6 спортын төрлөөр 11 (1 тамирчин допингийн шалтгаанаар оролцож чадаагүй) тамирчин эрхээ авч оролцлоо.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| Тивийн аварга шалгаруулах тэмцээн /тивийн наадам/-ээс авах медаль                                                    | 45  | 37  | 2024 онд Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүн нь тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 6 алт, 11 мөнгө, 20 хүрэл медаль тус тус хүртлээ. Тивийн наадам 4 жилд 1 удаа зохион байгуулагддаг тул 2024 онд зохион байгуулагдаагүй болно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| <b>71703 Аялал жуулчлал</b>                                                                                          |     |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| ОУ болон орон нутгийн чанартай авто зам дагуу шинээр байгуулах ариун цэврийн байгууламж бүхий үйлчилгээний цогцолбор | 10  | 0   | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс аймаг Наранбулаг, Цагаанхайрхан сум/ 1 төсөл арга хэмжээ батлагдсан. Гүйцэтгэгч шалгарсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| Отоглох цэг /өссөн дүнгээр/                                                                                          | 55  | 40  | Байгаль, түүх, соёлын өв бүхий жуулчдын зорин очих газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах газрын байршлыг аймаг орон нутгаас санал авч тодорхойлсон.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд 9 байршилд отоглох цэг байгуулахаар төлөвлөн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/168 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулан нээлттэй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.                                                                                                                                     |
| Шинээр болон шинэчлэн боловсруулах стандарт /өссөн дүнгээр/                                                          | 11  | 5   | 5 стандартын төсөл боловсруулсан.<br>- MNS 4588:2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ-Зочид буудалд тавих ерөнхий шаардлагын стандарт;<br>- MNS 5927:2008 Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлагын стандарт<br>- MNS 6043:2019 Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлагын стандарт<br>- MNS 5738:2007 Аялал жуулчлал. Дэн буудал. Ерөнхий шаардлагын стандарт<br>-Гэр буудлын стандарт                                                                                                                                                                 |
| Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүний тоо                                   | 100 | 350 | Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын өөрчлөлт, шинэчлэлтийн талаар үндэсний хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрэх, хамтран ажиллах зорилтыг хэрэгжүүлэхээр “Аялал жуулчлалын хөгжилд нутгийн иргэдийн оролцоо” сургалт, зөвлөгөөнийг Хөвсгөл аймгийн Мөрөн хотод 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, Хэнтий аймгийн Чингис хотод 2024 оны 05 дугаар сарын 9-ний өдөр, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр, Завхан аймгийн Улиастай хотод 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр тус тус төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог ханган зохион байгуулсан. |
| Монгол Улсыг сонирхсон гадаадын жуулчдын цахим хандалт                                                               | 30  | 20  | ССАЖЗЯ-ны цахим хуудасны аялал жуулчлалын мэдээллийн хандалтын давхардсан тоо 2,521,200                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

|                                                                                 |          |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|---------------------------------------------------------------------------------|----------|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Гадаад, дотоодод зохион байгуулах арга хэмжээ                                   | 83       | 156  | 2024 оны аялал жуулчлалын эвент календарьт 151 арга хэмжээ тусгагдаж, олон улсын 5 үзэсгэлэн /Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотод зохион байгуулагдсан "Хятадын аялал жуулчлалын үзэсгэлэн-СОТТМ, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхай хот - CITM, Япон улсын Токио хотод зохион байгуулагдсан "TOURISM EXPO JAPAN 2024" Япон аялал жуулчлалын үзэсгэлэн, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Лондон хотноо зохион байгуулагдсан "World Travel Market- 2024", Швейцарын Холбооны Улсын Мартини хотод 9 дүгээр сарын 27-оос 10 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан "Валэгийн үзэсгэлэн яармаг" (Foire du Valais)/ арга хэмжээнд оролцсон. |
| Хүлээн авах гадаадын жуулчид /мянган хүн/                                       | 1,000.00 | 809  | 2024 онд Монгол Улсад ирсэн жуулчдын тоо. /өссөн дүнгээр/                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлт /индекс/                   | 78       | 85   | Дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексээр 2019 онд 4.3 оноогоор 140 улсаас 76-рт, 2021 онд 4.5 оноогоор 117 улсаас 72-рт жагсаж байсан бол 2024 онд 3.57 оноогоор 119 улсаас 85-рт эрэмбэлэгдэж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>72209 Залуучууд</b>                                                          |          |      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын нийт залуучуудад эзлэх хувь | 45       | 17.7 | 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" УИХ-ын 13 дугаар тогтоолоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам байгуулагдаж, залуучуудын асуудлыг шилжүүлэх шийдвэр гарсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2024 оны статистик мэдээ

### 3.5.5 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 3,471.9 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 18,215.7 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт туссан хөрөнгөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 26,159.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 16,995.6 сая төгрөг нийт 64,842.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, хөрөнгийн зардалд 229.1 сая төгрөг, урсгал зардалд 56,874.3 сая төгрөг зарцуулж, 7,754.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.


Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.6 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 863,094.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 244,691.4 сая төгрөгөөр санхүүжүүлэх 141 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлагдаж 180,375.3 сая төгрөгийн санхүүжилт олгон 73.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын нийт 120,280.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй, 86 төсөл арга хэмжээний гэрээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар, 1,794.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй, 17 төсөл арга хэмжээг ерөнхий гэрээний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээг байгуулсан.

Гүйцэтгэлээр 234,571.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 114 арга хэмжээг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.



## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангах, төсөвт зохицуулалт хийхдээ журам зааврыг баримтлах, зардлыг зөв ангилан бүртгэх, үйл ажиллагааны орлогыг төлөвлөх, холбогдох журам зааврыг сайжруулах, мөрдөж ажиллах, батлагдсан бүтэц орон тоог бүрдүүлэх, биет бус хөрөнгийн бүртгэл, хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсүх, аудитор Б.Батхишиг нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 3/157 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 575,318.0 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг 5,753.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд төлөвлөөгүй ч гүйцэтгэлээр харьяа байгууллагууд төрийн хэмнэлтийн хуулийг зөрчсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар байгууллага нь албан хаагчдад хэмнэлтийн горимд шилжин ажиллах талаар үүрэг чиглэл өгч, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө тусган өр төлбөрийг барагдуулах, бичиг хэрэг, ашиглалтын зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Нийт 166,647.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 8,578.4 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,211.7 сая төгрөг, Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 180.4 сая төгрөг, норматив зардал 102.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 10,159.0 урсгал шилжүүлэг 3,843.5.0 сая төгрөгөөр зардал тус тус хэмнэгдсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

##### **Түүврийн байгууллага**

##### **Монгол кино нэгтгэл ТӨҮГ**

1. Шилэн дансны мэдээллийн санд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 1 гүйлгээг давхардуулан илүү мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1 мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийн санд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын гүйлгээг тухай бүр бүрэн оруулж хэвших.

##### **Аудитын илрүүлэлт:**

Шилэн дансны мэдээллийн санд харьяа 95 байгууллага 14,361.9 сая төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

##### **Харьяа байгууллагууд**

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 20,329.9 сая төгрөгийн 209 зөрчил илэрснээс 12.7 сая төгрөгийн 21 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,905.5 сая төгрөгийн 66 зөрчилд албан шаардлага, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцуулах 8 албан шаардлага хүргүүлж, 8,411.7 сая төгрөгийн 114 зөрчилд зөвлөмж өгсөн.

##### **Түүвэрт хамрагдсан байгууллагууд**

##### **Албан шаардлага**

##### **Кино урлагийг дэмжих сан**

1. Тус сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгосон санхүүжилтээр 2023-2024 онд хэрэгжсэн 8 төсөл болон тайлант онд тус сангаас 254.0 сая төгрөгийн санхүүжилт авсан 3 төслийн гүйцэтгэлийн явцын болон эцсийн тайланг хүлээн аваагүй, үр дүнг үнэлээгүй, гэрээний хэрэгжилтийн хангуулж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 132 дугаар тушаалаар батлагдсан "Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкийг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, хяналт тавих журам"-ын 13.5 "Төсөл, арга хэмжээг

хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд гүйцэтгэсэн ажлын төсвийн зарцуулалт, хүрсэн үр дүн, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, гүйцэтгэлийн тайланг гэрээнд заасан хугацаанд Зөвлөлд танилцуулах үүрэгтэй", Кино урлагийг дэмжих сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийн гэрээний 5. "Төслийн гүйцэтгэлд хяналт тавих", 14 "Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах", 15 "Хариуцлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн гүйцэтгэлийн явцын болон эцсийн тайланг хүлээн аваагүй, үр дүнг үнэлээгүй, гэрээний хэрэгжилтийн хангуулж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь кино урлагийг дэмжих сангаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх "Хувь хэмжээ тогтоох тухай" тушаалыг 2024 оны 10 дугаар сарын 8-ны өдөр гаргасан нь холбогдох журамд "тухайн жилд төсөл арга хэмжээг 2-оос доошгүй удаа сонгон шалгаруулах" гэж заасныг хэрэгжүүлэхэд цаг хугацааны хувьд боломжгүй нөхцөл үүсгэсэн байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 132 дугаар тушаалаар батлагдсан "Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкныг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, хяналт тавих журам"-ын 3.4 "Зөвлөл нь санхүүжилт болон зээл хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлтийг жилд 2-оос доошгүй удаа цахим хэлбэрээр хүлээн авна. Хүсэлт хүлээн авах товыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох бөгөөд олон нийтэд зарлах ажлыг Зөвлөл зохион байгуулна. Тухайн төсвийн жилд санхүүжилт болон зээл олгох төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах эхний зарыг төсөв батлагдсанаас хойш ажлын 20 хоногийн дотор зарлах арга хэмжээ авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кино урлагийг дэмжих сангаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх "Хувь хэмжээ тогтоох тухай" тушаалыг журамд заасан төсөл сонгон шалгаруулах, хүсэлт хүлээн авах хугацаатай уялдуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

## **Монгол кино нэгтгэл ТӨҮГ**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын албан хаагчдад байгууллагын дүрэмд тусгагдсан цалингийн нэмэгдлийн олгодоггүй, хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тодорхойлох, ажилтныг сургах, мэргэшүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2 "хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөх, ажилтанд ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний хувийг баталгаажуулж өгөх", Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын дүрмийн 6.13.9 "батлагдсан орон тооны хязгаар болон ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг батлагдсан цалингийн санд багтаан тогтоох, мөрдүүлэх, нийгмийн баталгааны арга хэмжээ авах", 6.13.10 "үйлдвэрийн газрын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, нийтлэг үйлчилгээний чиглэлээр ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгадагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

## **Зөвлөмж**

### **Кино урлагийг дэмжих сан**

1. Кино урлагийг дэмжих сан нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуульд заасан хугацаа хоцроож 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Кино урлагийг дэмжих сангийн санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж хэвших

2. Гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд Кино урлагийн зөвлөлөөс тусгай зөвшөөрөл олгон, зураг авч буй гадаадын иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж, санал, дүгнэлт гаргахаар журамд заасан боловч хэрхэн хяналт тавих талаар холбогдох журам, заавар тодорхойгүй, хоорондоо уялдаагүй байна.

Энэ нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Гадаадын иргэн, хуулийн этгээдэд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөл олгосныг зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээг олгож баталгаажуулна", Гадаадын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд Кино урлагийн зөвлөлөөс тусгай зөвшөөрөл олгодог бөгөөд Засгийн газрын 2022 оны 90 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Кино урлагийн зөвлөлийн ажиллах дүрэм"-ийн 2.1.3 "Кино урлагийг дэмжих тухай хуулийн 20.1-д заасан зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж, санал, дүгнэлт гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Кино урлагийн зөвлөлөөс тусгай зөвшөөрөл олгон, зураг авч буй гадаадын иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавих тогтолцоотой болох

3. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдлийг төсөл тус бүрээр гаргаагүй нэгдсэн байдлаар гаргасан байна. Мөн "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийн тайлбар хэсэгт хамааралт бүхий төсөл, арга хэмжээний нэрийг бичээгүй байна.


Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 “Тусгай сангийн эх үүсвэрээр төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу тухай бүр авч хэрэгжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн тайлбар хэсэгт хамаарал бүхий төсөл, арга хэмжээний нэрийг бичиж байх.

### **Кино урлагийн зөвлөлийн ажлын алба**

1. Кино урлагийн зөвлөлийн ажлын алба нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуульд заасан хугацаа хоцроож 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж,



аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж хэвших.

#### **Соёл урлагийг дэмжих сан**

1. Тайлант онд соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр 18 төсөл, арга хэмжээнд 636.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сар бүрд байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлээгүй байна. Мөн Соёл, урлагийг дэмжих сангийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх тусгайлсан цахим хуудас байхгүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 "Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний мэдээлэл холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сар бүрд байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан ил тод мэдээлж байх.

2. Соёл, урлагийг дэмжих сангийн тайлант оны хөрөнгийн зарцуулалтад төсвийн ерөнхийлөн захирагчийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгээгүй байна. Мөн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрх шилжүүлсэн тушаалд заасан төсөл, арга хэмжээний тайланг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосон боловч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 "Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн тайлант оны хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийх ажлыг тодорхой журамлан тогтмол хийж байх.

3. Соёл урлагийг дэмжих сангаас 2024 онд сонгон шалгаруулсан 18 төсөл арга хэмжээнээс 13 төслийг гэрээнд заасан хугацаанаас 7-14 хоногийн дараа хүлээж авсан байна. Мөн ARTIFIED Virtual Art Gallery төсөл, арга хэмжээний тухайд гүйцэтгэсэн ажлын тайланг 2024 оны 12 сарын 15-ны өдөр албан бичгээр ирүүлсэн байхад гэрээ дүгнэсэн актыг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр буюу баримт бичиг ирүүлэхээс өмнөх хугацаагаар дүгнэсэн байна.

Энэ нь ажил гүйцэтгэх гэрээний 7 дугаар зүйл "Ажил гүйцэтгэх хугацаа", 8 "Ажлын гүйцэтгэлд хяналт тавих", 11" Ажлын гүйцэтгэлийг хүлээлцэх", 18 дугаар зүйл "Хариуцлага" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэх хугацааг гэрээнд бодитой тусган гэрээний хугацааг хоцрооход ногдуулах хариуцлагыг гэрээний үнийн дүнтэй уялдуулан тогтоож мөрдүүлэх.

4. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын соёл, урлагийн бодлогын зохицуулалтын нэгж нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй, үр дүнг тооцоогүй, төсөл, хөтөлбөртэй холбоотой мэдээ, тайлан гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4.5 "соёл,

урлагийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж, үр дүнг тооцох, эдгээртэй холбогдсон мэдээ, тайлан гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, үр дүнг тооцох, холбоотой мэдээ, тайлан гаргах үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллагын болон соёл, урлагийн бодлогын зохицуулалтын нэгжийн уялдааг хангаж ажиллах.

5. Соёл урлагийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдлийг төсөл тус бүрээр гаргаагүй нэгдсэн байдлаар гаргасан байна. Мөн "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийн тайлбар хэсэгт хамааралт бүхий төсөл, арга хэмжээний нэрийг бичээгүй байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 "Тусгай сангийн эх үүсвэрээр төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу тухай бүр авч хэрэгжүүлнэ. Засгийн газрын 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ын 3.10. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу тухай бүр авч хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдэгдлийг төсөл тус бүрээр гаргаж байх.

6. Соёл, урлагийг дэмжих сангаас 2024 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулах ажлын хэсгийн эхний хурал тайлант оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулагдах байтал журамд заасан хугацааг баримтлалгүй 2 дугаар улирлаас хойш буюу 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан байна.

Энэ нь Соёл урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 3.1. "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүлээн авах хугацаанаас нэг сараас багагүй хугацааны өмнө жил бүрийн I улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахимаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Төслийг хүлээн авахаар зарлагдсанаас бусад хугацаанд төсөл хүлээн авахгүй", 3.3 "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын соёл, урлагийн бодлогын зохицуулалтын нэгж нь энэ журмын 3.1-д заасан хугацаанаас хойш ажлын 10 хоногийн дотор энэ журмын 2.2-т заасан ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, төсөл, арга хэмжээг хэлэлцүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төслийн сонгон шалгаруулах ажлын хэсгийн ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангаж, хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээг тодорхой болгон журамлах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар нийт 584.3 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс 48.9 сая төгрөгийн 4 хариуцлага тооцох албан шаардлага, 487.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 48.2 сая төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 91.7 хувьтай хэрэгжсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул зөрчлийг таслан зогсоох, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт                          | Өмнөх аудитын үзүүлэлт |              | Биелэлт  |              |             |
|-----------------------------------|------------------------|--------------|----------|--------------|-------------|
|                                   | Тоо                    | Дүн          | Тоо      | Хувь         |             |
| Хариуцлага тооцох албан шаардлага | 4                      | 48.9         | 4        | 48.9         | 100.0       |
| Албан шаардлага                   | 3                      | 487.2        | 3        | 487.2        | 100.0       |
| Зөвлөмж                           | 3                      | 48.2         | 2        | 48.2         | 75.0        |
| <b>Нийт дүн</b>                   | <b>10</b>              | <b>584.3</b> | <b>9</b> | <b>584.3</b> | <b>91.7</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд үндсэн үйл ажиллагааны орлого 5,067.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны 3,654.8 сая төгрөгийн орлого олсныг тухайн орлогыг олохтой холбоотой зардалд зарцуулсан болон үнэн зөв тайлагнасан эсэх асуудал;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт, барьцаа хөрөнгө, техник хяналт дансаар хийсэн ажил гүйлгээг яамны аппаратын буюу төсвийн шууд захирагчийн улсын бүртгэлийг ашиглан хийж байгаа боловч өөр төсвийн байгууллагаар тусад нь тайлагнаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн статусаар шилэн дансанд эрх үүсгэж ирсэн нь цалингийн зардлаас бусад орлого, зарлагыг мэдээлэх боломжгүй гэх мэт эрсдэлийг үүсгэж байгаа асуудал;
- Соёлын төв өргөөний барилгын зарим хэсгийг зориулалтын бусаар ашиглуулж, түрээсэлж байгаа боловч соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллага өөрийн гэсэн байргүй байгаа асуудал;
- Он дамжсан хөрөнгө оруулалтын өглөгийг барагдуулсан байдал;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 93,121.9 сая төгрөгийн 524 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

**Залруулсан алдаа:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд буруу тусган илэрхийлсэн 9,155.8 сая төгрөгийн 6 алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 50.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 208.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 340.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 978.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 4,448.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Нэмэлт санхүүжилтийн тайланд Кино урлагийг дэмжих сангийн 3,129.3 сая төгрөгийн эх үүсвэрийг зөрүүтэй тайлагнасан.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 36,390.7 сая төгрөгийн 850 зөрчил илэрснээс хууль хяналтын байгууллагад 3 байгууллагын 236.0 сая төгрөгийн 5 асуудлыг шилжүүлж, 36,154.4 сая төгрөгийн зөрчлөөс 1,368.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 194 төлбөрийн акт тогтоож, 28,883.4 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 277 албан шаардлага хүргүүлж, 5,902.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, санхүүгийн удирдлагыг сайжруулах 363 зөвлөмж өгч, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцуулах 11 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 36,390.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 496 байгууллага, сан, зардлын санхүүгийн тайлан нэгтгэгдэхээс 161 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзаж, 333 байгууллагыг аудитын түүвэрт хамруулж, 2 байгууллага дараах шалтгаанаар аудитад хамрагдаагүй.

Спортыг дэмжих сан төсөв батлагдсан ч гүйцэтгэл гараагүй, биеийн тамир спортын улсын хорооны хөрөнгө оруулалт шинэ бүтэц зохион байгуулалтаар Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалтад нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 136 дүгнэлт, “Хязгаарлалттай” 22 дүгнэлт, Биеийн тамир, спортын улсын хороо, Хэнтий аймгийн орон нутгийн судлах музейд “Сөрөг” дүгнэлт, Соёл урлагийн газрын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд “Татгалзсан” дүгнэлт өгсөн.

### 5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 5.2.1 Албан шаардлага

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас тайлант онд санхүүгийн тайлангийн аудитын 36,154.4 сая төгрөг, нийцлийн аудитын 20,329.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 “эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3 “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулан ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний 42 байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 618.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-т заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-т зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, 15.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх, 15.1.5. төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2 "эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Байгалийн түүхийн музейн захирал өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, Соёл урлагийн газрын төвлөрүүлэн захирагч "Татгалзсан" дүгнэлт, Биеийн тамир, спортын улсын хорооны төвлөрүүлэн захирагч "Сөрөг" дүгнэлт авсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2 "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж тус тус заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг, Татгалзсан дүгнэлт авсан, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.3 Түүврийн байгууллага

#### 5.3.1 Төлбөрийн акт

**Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалт, барьцаа**

1. Засгийн газрын 2020 оны 253, 2022 оны 495, 2023 оны 456 дугаар тогтоолуудыг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хэрэгжээгүй 13 хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилт нийт 1,081.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7. Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ. 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлээгүй, барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй нийт 1,081.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

#### 5.3.2 Албан шаардлага

1. Барьцаа хөрөнгийн дансанд 2021-2023 онуудад үүссэн гэрээний маргаантай, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, 2025 онд санхүүжих төсөв батлагдаагүй зэрэг нийт 5,960.2 сая төгрөгийн дуусаагүй 10 төсөл арга хэмжээний үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8 "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.9 "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналтыг хэрэгжүүлэх, хянан баталгаажуулах", 2.2.14 "Тухайн жилийн төсвийн тухай хуулиар өөрийн багцад батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний маргаантай, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, 2025 онд санхүүжих төсөв батлагдаагүй зэрэг шалтгаанаар хэрэгжихгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

**Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөтөлбөр, арга хэмжээ**

1. "Юнеско дэлхийн дурсамж ерөнхий чуулган"-ыг 29.9 сая төгрөгөөр, "Go Mongolia" арга хэмжээг 207.9 сая төгрөгөөр нийт 237.8 сая төгрөгийн арга хэмжээг зохион байгуулахдаа нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 6 дугаар зүйлийн 6.1 "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх

зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрэсэн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Салбарын ажилтны нэгдсэн зөвлөгөөн, "Go Mongolia" арга хэмжээ, Монголын музейн хөгжил ном, залуу мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөр зэрэг байгууллага, хамт олныг сурталчлахтай холбоотой ажилд 76.9 сая төгрөг, зочин, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад 29.7 сая төгрөг, нийт 106.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4.1.6 "сахилга баттай байх", 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх, 15.1.5. төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

### **Монгол кино нэгтгэл ТӨҮГ**

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 69 нэр төрлийн 103.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

#### **Соёл урлагийг дэмжих сан**

1. Соёл урлагийг дэмжих сан соёлын өвийг хамгаалах тухай хуульд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна гэж заасан боловч тооллогын ажилд шаардагдах төсвийг батлаагүй, тооллогын ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна", Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ын 2.6 "Тооллогын комисс тооллогын ажлыг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, энэхүү журамд нийцүүлэн үнэн зөв, шуурхай, чанартай зохион байгуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

#### **5.3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **5.3.3.1 Томилолтын зардалтай холбоотой асуудал**

#### **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хөтөлбөр арга хэмжээ**

1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хөтөлбөр арга хэмжээний зардлаас тайлант хугацаанд гадаад, дотоод томилолтод 35.9 сая төгрөгийг яамны тухайн арга хэмжээ хариуцсан мэргэжилтнүүдийн дансанд шилжүүлж зарцуулсан нь гүйцэтгэлд тавих хяналтыг сулруулж байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтын зарцуулалт, үр дүнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

##### **5.3.3.2 Орлоготой холбоотой асуудал**

#### **Кино урлагийг дэмжих сан**

1. Тайлант онд Кино урлагийг дэмжих тухай хуульд гадаадын киног Монгол Улсад гаргасны ашгийн 2 хувийг кино урлагийг дэмжих санд төвлөрүүлэх тухай нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд хуульд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх болон орлогын эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Кино урлагийг дэмжих сан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс болон гадаадын киног Монгол Улсад гаргасны ашгийн 2 хувиас бүрдэх бөгөөд уг сангаас дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ" /2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт өөрчлөлт/ гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид хууль, тогтоомжийг мөрдөж, санд төвлөрүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

### **5.3.3.3. Зардалтай холбоотой асуудал**

#### **Кино урлагийг дэмжих сан**

1. Кино урлагийг дэмжих сангаас өмнөх онуудад санхүүжиж хэрэгжсэн 727.2 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээг 2023 оны санхүүгийн тайланд зардлаар бүртгэх ёстой байсан хэдий ч орхигдуулж, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрөн бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3 “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг стандарт, хууль эрх зүйд нийцүүлэн үнэн зөв тайлагнах, зардлын бүртгэл, тасалбар болголтыг баримталж толилуулж байх.

2. Кино урлагийг дэмжих сангаас эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр иргэн, хуулийн этгээдэд санхүүжилт олгохдоо 1,126.7 сая төгрөгийн 19 гүйлгээг тооцоо үүсгэлгүйгээр шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3 дугаар бүлэг “Зардал” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх.

#### **Кино урлагийн зөвлөлийн ажлын алба**

1. Кино урлагийн зөвлөлийн ажлын албаны зардлын данснаас 499.7 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлж, үнэн зөв тайлагнах.

2. Кино урлагийн зөвлөлийн ажлын алба нь Бүгд Найрамдах Франц Улсын Канн хотноо жил бүр зохион байгуулагддаг Каннын 77 дахь удаагийн олон улсын кино наадамд Кино урлагийн зөвлөлийн ажлын албаны 4 албан хаагч, Соёлын яамны 1 албан хаагч болон 4 уран бүтээлч нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй оролцсоноос тухайн 4 уран бүтээлчийн кино төслийг хэрхэн сонгон шалгаруулах тухай тусгайлсан журам байхгүй, хөрөнгө зарцуулах эдийн засгийн ангилал, хууль эрх зүйн үндэслэл тодорхойгүй байхад нийт 50.3 сая төгрөгийг Соёлын яамны нэмэлт санхүүжилтийн данснаас олгож зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам” 1.1. Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан нөхөх төлбөрийг олгоход энэ журмыг баримтална. Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйл Төрийн албан хаагчид олгох нөхөн төлбөр 59.1.1 албан томилолтын зардлыг; Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” Томилолт зочны зардал” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох хууль, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах.

#### **Соёл урлагийг дэмжих сан**

1. Соёл, урлагийг дэмжих сангийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд нь зардал баталж, эрх шилжүүлсэн тушаалаа 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гаргасан нь сонгон шалгарсан төсөл, арга хэмжээнд шаардлагатай төсвийг гүйцэтгэлээр санхүүжүүлэлгүй жилийн эцэст буюу төсөл арга хэмжээ аль хэдийн хэрэгжиж дууссаны дараа олгож байгаа нь төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг дутагдах, төслүүд хугацаандаа хэрэгжихгүй байх зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгож байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 "урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сангийн хөрөнгөнөөс зардал баталж, эрх шилжүүлэх тушаалыг журамд заасан төсөл сонгон шалгаруулах, хүсэлт хүлээн авах хугацаатай уялдуулах

#### **5.3.3.4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **Кино урлагийн зөвлөлийн ажлын алба**

1. Кино урлагийн зөвлөлийн ажлын алба нь үйл ажиллагаандаа зориулан байгууллагын цахим хуудас болох <https://filmmongolia.gov.mn/>, төсөл хүлээж авах бүртгэлийн программ болох <https://kuds.filmmongolia.gov.mn/auth/login> сайтуудыг ашигладаг боловч тус цахим хуудаснууд нь байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлгүй байна. Тухайн цахим хуудаснуудыг гүйцэтгүүлсэн гэрээ, хүлээн авсан тухай гэрээ дүгнэсэн акт байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 5.1.4.үнэн зөв байх; 14 дүгээр зүйлийн 14.4 .Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ; -ийн 14.4.2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнаж байх.

#### **5.3.3.5. Урьдчилж төлсөн зардалтай холбоотой асуудал**

##### **Чингис хааны өв соёлын хүрээлэн**

1.Чингис хаан ба Монголын эзэнт гүрнийг судлах хөтөлбөрийн хүрээнд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн хаант улсын Кембрижийн их сургуульд 2025 оны хичээлийн жилд судалгааны тэтгэлэгт хамрагдах судлаачийн төлбөр болох 341.7 сая төгрөгийг урьдчилан шилжүүлж, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны "Ангилал шинэчлэн батлах тухай" 211 тоот тушаалын 2183."Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардалд Төрийн албаны хууль, ахмад настны тухай хууль болон эрх зүйн актын дагуу Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр, нийтлэг баталгаа, нэмэгдэл баталгаатай тус тус холбоотой ажил олгогчоор дамжуулан олгох нэг удаагийн тэтгэмж, дэмжлэг" хамрагдана. 213301- Сургалт семинарын зардалд "Мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад дотоодын сургалтын төлбөр, тээвэр, байр хоолны зардал, сургалтын материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх, аман болон бичгийн орчуулгын зардал" зэрэг хамрагдана" гэж заасантай нийцэхгүй байна.



Өгсөн зөвлөмж Чингис хаан ба Монголын эзэнт гүрнийг судлах хөтөлбөрийн хүрээнд судалгааны тэтгэлэгт хамрагдах судлаачийн төлбөрийг урьдчилан шилжүүлж байгаа асуудлыг хянаж, холбогдох стандарт, журмын дагуу бүртгэлийг хөтөлж байх.

2.Ном, сэтгүүл авахаар нэр бүхий 2 байгууллагатай гэрээ байгуулан нийт 28.2 сая төгрөг шилжүүлснийг байгууллагаас авах авлагаар бус урьдчилж гарсан зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “Санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 7 дугаар зүйлийн 7.1 “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3 “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                                     | 1  | -   | -   | -   | 1  | - | - | - | -   | - | -  | - |
| Нийт дүн                                                                          | 19 | 363 | 115 | 136 | 23 | 2 | 1 | 1 | 333 | 2 | 2  | 2 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1022/АОЧ/241

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний 42 байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж 618,669,194.40 /зургаан зуун арван найман сая зургаан зуун жаран есөн мянга нэг зуун ерэн дөрвөн/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 12 дугаар зүйлийн 12.1 "Энэ хуулийн 3.1-т заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12 дугаар зүйлийн 12.1.4 "хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг санхүүжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-т зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4 "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох, 15.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх, 15.1.5. төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд /Ч.Номин/-д даалгав.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Д.ЗАГДЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 1023/А0111249

Улаанбаатар хот

СНАГ-2025/020/НА-СТА-Т63

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс тайлант онд санхүүгийн тайлангийн аудитын 36,154,412,475.76 /гучин зургаан тэрбум нэг зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун арван хоёр мянга дөрвөн зуун далан таван/ төгрөг нийцлийн аудитын 20,329,879,806.20 /хорин тэрбум гурван зуун хорин есөн сая найман зуун далан есөн мянга найман зуун зургаан/ төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулан зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулан ажиллаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд /Ч.Номин/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА өгсөн:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Цэнгэлдэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3  
Утас 51-264710

Засгийн газрын 4 дүгээр байр,

Z:\Alban Shaardlaga\2025\0425 SNAG-3.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1024/А0111241

Улаанбаатар хот

СНАГ-2025/0201/НА-СТА-Т63

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Байгалийн түүхийн музейн захирал өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй, Соёл урлагийн газрын төвлөрүүлэн захирагч "Татгалзсан" дүгнэлт, Биеийн тамир, спортын улсын хорооны төвлөрүүлэн захирагч "Сөрөг" дүгнэлт авсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2 "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж тус тус заасан үндэслэл бүрдсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2 "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь.

1. Санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг, Татгалзсан дүгнэлт авсан, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд /Ч.Номин/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАГДЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1087/АО111241

Улаанбаатар хот

СНАГ-2025/008/НА-СГА-ЗРТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь кино урлагийг дэмжих сангаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх "Хувь хэмжээ тогтоох тухай" тушаалыг 2024 оны 10 дугаар сарын 8-ны өдөр гаргасан нь холбогдох журманд "тухайн жилд төсөл арга хэмжээг 2-оос доошгүй удаа сонгон шалгаруулах" гэж заасныг хэрэгжүүлэхэд цаг хугацааны хувьд боломжгүй нөхцөл үүсгэсэн байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 132 дугаар тогтоолоор баталсан "Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банканд тавих шалгуур, банкныг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, хяналт тавих журам"-ын 3.4 "Зөвлөл нь санхүүжилт болон зээл хүссэн төсөл, арга хэмжээний хүсэлтийг жилд 2-оос доошгүй удаа цахим хэлбэрээр хүлээн авна. Хүсэлт хүлээн авах товыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох бөгөөд олон нийтэд зарлах ажлыг Зөвлөл зохион байгуулна. Тухайн төсвийн жилд санхүүжилт болон зээл олгох төсөл, арга хэмжээний хүсэлт хүлээн авах эхний зарыг төсөв батлагдсанаас хойш ажлын 20 хоногийн дотор зарлах арга хэмжээ авна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Кино урлагийг дэмжих сангаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх "Хувь хэмжээ тогтоох тухай" тушаалыг журамд заасан төсөл сонгон шалгаруулах, хүсэлт хүлээн авах хугацаатай уялдуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялаг жуулчлал, залуучуудын сайд /Ч.Номин/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага талбай-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlagal\2025\0425 SNAГ-36.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1088/АО11/241

Улаанбаатар хот

СНАГ-2025/001/НА-СТА-357С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулинд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна гэж заасан боловч тооллогын ажилд шаардагдах төсвийг батлаагүй, тооллогын ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т "Соёлын биет бус өвийн үзлэгийг гурван жил тутамд, түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогыг таван жил тутамд, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг дөрвөн жил тутамд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна", Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ын 2.6 "Тооллогын комисс тооллогын ажлыг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, энэхүү журамд нийцүүлэн үнэн зөв, шуурхай, чанартай зохион байгуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд /Ч.Номин/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264300

Z:\Alban Shaardlaga\2025\0425 SNAG-36.Docx



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1038/А016050

Улаанбаатар хот

СНАГ - 2025/115/НА-СТА-ТМЦ

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны барьцаа хөрөнгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2020 оны 253, 2022 оны 495, 2023 оны 456 дугаар тогтоолуудыг үндэслэн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хэрэгжээгүй 13 хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэл санхүүжилт нийт 1,081,850,589.07 /Нэг тэрбум наян нэгэн сая найман зуун тавин мянга таван зуун наян есөн/ төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7-т "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" 45 дугаар зүйлийн 45.2-т "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.2-т "төлөөлсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улсын төсөвт төвлөрүүлээгүй, барьцаа хөрөнгийн дансанд байршиж буй нийт 1,081,850,589.07 /Нэг тэрбум наян нэгэн сая найман зуун тавин мянга таван зуун наян есөн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Оюунбилэг/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Ж.Отгонбат/, ерөнхий нягтлан бодогч /П.Билгүүнтөр/ нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 1068/А0175177

Улаанбаатар хот

СНАГ- 2025/100/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийг тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 69 нэр төрлийн 103,208,468.00 /нэг зуун гурван сая хоёр зуун найман мянга дөрвөн зуун жаран найман/ төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл 31.1 "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирал /Б.Түмэн-өлзий/, ерөнхий нягтлан бодогч /Г.Төрбат/ нарт далангав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

*Г.Төрбат*

*Б.Түмэн-өлзий*

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Б.БАТХИШИГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 1009/А-0175177

Улаанбаатар хот

СНАГ-2025/100/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийг тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тус ТӨҮГ-ын дүрэмд тусгагдсан цалингийн нэмэгдлийг олгодоггүй, хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тодорхойлох, ажилтныг сургах, мэргэшүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2 "хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөх, ажилтанд ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний хувийг баталгаажуулж өгөх", Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын дүрмийн 6.13.9 "батлагдсан орон тооны хязгаар болон ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг батлагдсан цалингийн санд багтаан тогтоох, мөрдүүлэх, нийгмийн баталгааны арга хэмжээ авах", 6.13.10 "үйлдвэрийн газрын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, нийтлэг үйлчилгээний чиглэлээр ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирал /Б.Түмэн-өлзий/, ерөнхий нягтлан бодогч /Г.Төрбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Б.БАТХИШИГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9023030583

Z:\Alban Shaardlaga\2025\0423 SNAG-1.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1037/А016080

Улаанбаатар хот

СНАГ-2025/050/НА-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны барьцаа хөрөнгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барьцаа хөрөнгийн дансанд 2021-2023 онуудад үүссэн гэрээний маргаантай, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, 2025 онд санхүүжих төсөв батлагдаагүй зэрэг нийт 5,960,198,948.84 /Таван тэрбум есөн зуун жаран сая нэг зуун ерэн найман мянга есөн зуун дөчин найман/ төгрөгийн дуусаагүй 10 төсөл арга хэмжээний үлдэгдэл байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.8 "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.9 "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналтыг хэрэгжүүлэх, хянан баталгаажуулах", 2.2.14 "Тухайн жилийн төсвийн тухай хуулиар өөрийн багцад батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний маргаантай, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, 2025 онд санхүүжих төсөв батлагдаагүй зэрэг шалтгаанаар хэрэгжихгүй байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Оюунбилэг/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Ж.Отгонбат/, ерөнхий нягтлан бодогч /П.Билгүүнтөр/ нарт даалгав..

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ц.БАТСҮХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264200

ATA9643  
9023636383

Z:\Alban Shaardlagn\2025\0425 SNAG-3.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1039/A0160050

Улаанбаатар хот

СНАГ- 2025/050/НА-СТА-ТМЧ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Салбарын ажилтны нэгдсэн зөвлөгөөн, "Go Mongolia" арга хэмжээ, Монголын музейн хөгжил ном, залуу мэргэжилтнийг бэлтгэх хөтөлбөр зэрэг байгууллага, хамт олныг сурталчлахтай холбоотой ажилд 76,916,900.00 /далан зургаан сая есөн зуун арван зургаан мянга есөн зуун/ төгрөг, зочин, төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад 29,705,553.00 /хорин есөн сая долоон зуун таван мянга таван зуун тавин гурван/ төгрөг, нийт 106,622,453.00 /нэг зуун зургаан сая зургаан зуун хорин хоёр мянга дөрвөн зуун тавин гурван/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 4.1.6 "сахилга баттай байх", 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх, 15.1.5. төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Омунбилэг/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Ж.Отгонбат/, ерөнхий нягтлан бодогч /П.Билгүүнтөр/ нар даагав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ц.БАТСҮХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-1, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264130

602383657

Z:\Alban Shaardlaga\2025\0425 SNAГ-5.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1040/А0160090

Улаанбаатар хот

СНАГ - 2025/050/НА-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөтөлбөр, арга хэмжээний 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Юнеско дэлхийн дурсамж ерөнхий чуулган"-ыг 29,873,124.00 /хорин есөн сая найман зуун далан гурван мянга нэг зуун хорин дөрвөн/ төгрөгөөр, "Go Mongolia" арга хэмжээг 207,916,800.00 /хоёр зуун долоон сая есөн зуун арван зургаан мянга найман зуун/ төгрөгөөр нийт 237,789,924.00 /хоёр зуун гучин долоон сая долоон зуун наян есөн мянга есөн зуун хорин дөрвөн/ төгрөгийн арга хэмжээг зохион байгуулахдаа нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 "төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 6 дугаар зүйлийн 6.1 "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2025\0425 SNAG-5.Docx

1. Нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Оюунбилэг/, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Ж.Отгонбат/, ерөнхий нягтлан бодогч /П.Билгүүнтөр/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ц.БАТСҮХ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 1089/А0170433

Улаанбаатар хот

СНАГ-2025/008/НА-СТА-38ТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Кино урлагийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Тус сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгосон санхүүжилтээр 2023-2024 онд хэрэгжсэн 8 төсөл болон тайлант онд тус сангаас 254,000,000.00 /Хоёр зуун тавин дөрвөн сая/ төгрөгийн санхүүжилт авсан 3 төслийн гүйцэтгэлийн явцын болон эцсийн тайланг хүлээн аваагүй, үр дүнг үнэлээгүй, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан "Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт олгох болон банкинд тавих шалгуур, банкыг сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох, хяналт тавих журам"-ын 13.5 "Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд гүйцэтгэсэн ажлын төсвийн зарцуулалт, хүссэн үр дүн, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, гүйцэтгэлийн тайланг гэрээнд заасан хугацаанд Зөвлөлд танилцуулах үүрэгтэй", Кино урлагийг дэмжих сангаас эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилтийн гэрээний 5 дугаар бүлгийн 5.1 "Төсвийн гүйцэтгэлд Зөвлөл хяналт тавина", 5.3 "Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн явц, гүйцэтгэл, үр дүнг Зөвлөлд танилцуулж байх үүрэгтэй", 14 дүгээр бүлгийн 14.1 "Гэрээний нэг Тал гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд нөгөө талынхаа шаардсан хугацаанд уг зөрчлийг арилган, энэ талаар бичгээр мэдэгдэх ба уг хугацаанд зөрчлийг арилгаагүй, үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй нөхцөлд мэдэгдэл гаргасан тал гэрээг наг талын санаачилгаар цуцалж, төлбөр, зардал, хохирлоо шаардах эрхтэй", 15 дугаар бүлгийн 15.1 "Төсөл хэрэгжүүлэгч нь төслийг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл төслийг чанарын шаардлага хангаагүй байдлаар гүйцэтгэснээс тийнхүү төслийг хүлээлгэн өгөх хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Зөвлөлд төлнө" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн гүйцэтгэлийн явцын болон эцсийн тайланг хүлээн аваагүй, үр дүнг үнэлээгүй, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Кино урлагийн зөвлөлийн ажлын албаны дарга /Т.Ундрал/, Монгол кино дэмжих газрын дарга /Б.Болдбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Э.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 7-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

Z:\Alban Shaardlaga\2025\0425 SNAG-38.Docx

A blank sheet of white paper with horizontal ruling lines.



Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг